

МОНГОЛД 50 ЖИЛ АЖИЛЛАСАН ОРОСЫН КОНСУЛ

*Т.Цэцэгмаа**

Я.П.Шишмарев 1883 оны 9-р сарын 14-нд Өвөр Байгал мужийн Троицкосавск хотод төржээ. Түүний төрөл төрөгсдийн мэдээлснээр, өвөг эцэг нь цэвэр монгол цусны хүн байсан бөгөөд тэрээр Өвөр Байгал мужид ирж нутагшин оросын казак бүсгүйтэй гэрлэжээ. Шишмарев гуайн эцэг Парфений монголоор сайн ярьдаг байсан бөгөөд Хиагтын хилийн комиссарын албанд орчуулагч хийн, Оросын элчин, төлөөлөгчдийг Өргөө рүү дагалдан явдаг, Өргөөд алдартай нэгэн байв.

Яков хүү 1849 онд төрөлх хотноо Орос-монгол цэргийн сургууль дүүргэж 16 наснаасаа 1855 он хүртэл Хиагт хотын даргын бичиг хэргийн газар зэрэг олон газарт алба хашиж явжээ.

1860 оны 11-р сарын 2-нд Бээжин хотноо үзэглэсэн Орос-Хятадын гэрээний дагуу Монголд Орос улсын консулын газар нээгдсэн бөгөөд Оросын хаан хоёрдугаар Александр Өргөөд суух консулаар Крымын дайны баатар, язгууртан угсааны, 34 настай дэд хурандаа Константин Николаевич Боборыкиныг томилсон байна. Консулын газрын орчуулагч-нарийн бичгийн даргаар Дорнод Сибирийн амбан захирагч, гүн Н.М.Муравьевын санаачлага зөвлөгөөний дагуу Яков Парфеньевич Шишмарев томилогджээ. Тэднээс гадна консулын газарт Эрхүүгийн цэргийн эмнэлгийн эмч И.Осипов, П.Рогалевоор ахлуулсан 20 казак цэрэгтэй хамгаалалтын алба ажиллаж байв. Консул Н.К.Боборыкин Өргөөд 18 сар амьдраад эрүүл мэндийн улмаас 1863 оны хавар Орос орондоо булжээ. 1861 онд Я.П.Шишмарев консулын газрын захирагчаар, 1864 оны 2-р сарын 14-нөөс консулын үүрэг гүйцэтгэгчээр, 1865 оны 3-р сарын 2-ны өдрөөс консулаар томилогдсон ба харин 1881 оны Орос Хятад хоорондын Санкт-Петербургийн гэрээний дагуу Монголын Ховд, Улиастай хотуудад Оросын консулын газар байгуулагдахад тэрээр Ерөнхий консул болж Монголд 50 жилийн турш ажиллаж амьдарчээ.

1861 оныг хүртэл Орос Хятадын харилцаа нь доод түвшний – Хиагтын хилийн комиссарын, дунд түвшний – Хиагт хотын дарга – Өргөө хотын захиргаа, дээд түвшний – Төр засгийн Сенат – Бээжингийн гадаад харилцаа эрхлэх газар гэсэн давхарга, хүрээнд зохицуулагдан явагддаг байв. Өргөө хотод Орос улсын консулын

*Т.Цэцэгмаа - докторант, МУИС

газар нээгдсэнээр Хиагт хотын ач холбогдол багасч доод ба дунд түвшний хүрээний асуудлууд Өргөөгийн консул дээр төвлөрсөн байна. Өргөө дахь консулын газар нь оросын худалдаачдыг тал бүрээр дэмжих, Орос-Хятадын худалдааны гэрээнүүдийн нөхцлийг хангаж ажиллах, монголчуудын хувьд гэвэл тэдэнд оросуудад сайн хандах, нөхөрлөх сэтгэл төрөхүйцээр харилцах чиглэл зөвлөмжтэй байв.

Монгол дахь Оросын консулын газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийн нэг нь орос-монголын худалдааг хөгжүүлэх явдал байв. Монголчууд Оросын барааг мэддэг ч Я.П.Шишмаревын тооцоолсоноор тэр үед Монголд 10000 хол давж байсан хятадын наймаачдаас л худалдан авах боломжтой байв. Шишмаревын бодлоор орос худалдаачид хятад наймаачдын өрсөлдөөнийг давахын тулд алслагдсан хошуудаар явж, монголчуудын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхлыг сайтар судлан, хэрэгцээг нь хангаж ажиллах шаардлагатай байлаа. 1881 оны Санкт-Петербургийн гэрээнд зааснаар хил орчмын хүн ам хилийн дагуу хааш хаашаа 500 километр зурвас газарт харилцан хил давж оросууд Монгол руу өвс, загас авахаар, тариа буудай зөөж, хятад, монголчууд орос тосгон, суурингаар яван шаардлагатай бараагаа олж авдаг байжээ.

Зам харгуй, холбоо харилцаа муу нөхцөлд Я.П.Шишмарев орос-монголын худалдаа арилжааг хөгжүүлэх бүхий л аргыг эрэлхийлж, энэ ажилд нь түүний томилсон арилжааны ахлагч нар жил бүрийн наймаа арилжааны явцын тайлан гаргах зэргээр тусалдаг байв. Нутгийн ардууд орос худалдаачдын хоорондын харилцаа ч “үүлгүй тэнгэр” мэт байсангүй. Ийм байдал, ялангуяа хүн ам нь бийлэгжүү амьдралтай, мал сүрэг арвинтай, ангийн арьс үс элбэгтэй, газар тариалан ч эрхэлдэг баруун Монголд орос худалдаачид нутгийн ардуудын газрыг эзлэн түрэмгийлэх, тооцоон дээрээ луйвардах, хулгайлагдсан мал худалдан авч эздэд нь баригдсан ч буцаан өгөхгүй байх зэрэг үйлдлийн хариуд нутгийн ард түмэн орос худалдаачдын жингийн цувааг дээрэмдэх зэргээр хурц зөрчил илэрдэг байв. 1868 оны эхээр Я.П.Шишмарев урьд нь очиж байгаагүй энэ хязгаар нутгийг үзэх, нутгийн удирдлага, хүмүүстэй танилцах, орос иргэд, нутгийн хүн амын хоорондын хэл ам, хэрүүл тэмцлийг нэг тийш болгохоор шийдэн 1868 оны 7-8 дугаар сард Ховд, Улиастайд очсоноор тэр үед хуримтлагдсан бүх маргаантай асуудлууд шийдвэрлэгджээ.

Орос улс Манж хятадын эрхшээл дор байсан Монгол улстай ХҮИ-ХИХ зууны турш хөрш зэргэлдээ оршиж байсан ч Монгол орон

Орос орны хувьд хаалттай хэвээр байсан бөгөөд Я.П.Шишмарев монгол судлал, тэр дундаа манай орныг газарзүйн талаас нь анхлан судлагсадын нэг болсон байна. Тэрээр Оросын Газарзүйн нийгэмлэгийн Сибирийн салбарт Монголын нийт нутгийн болон Цэцэнхан аймгийн газрын зургийг гаргаж өгсөн бөгөөд энэ зураг дээр Цэцэнхан аймгийг хошуудад хуваан, Хэрлэн, Сэлэнгэ голуудын эхийг тодруулан, Хангай, Монгол Алтайн нуруудын мөнх цаст оргилуудыг тэмдэглэсэн байна. Хэрлэн голын сав газрын тухай түүний замын тэмдэглэл удаан хугацааны турш гадны судлаачдад Монголын энэ хавийн нутаг орны талаарх цорын ганц баримт болж байжээ.

Түүний эрдэм шинжилгээний ажилд Монголын угсаатны судлалын асуудлууд мөн тусгалаа олж байсан бөгөөд, тэрээр 1871 онд Оросын Газарзүйн нийгэмлэгийн Сибирийн салбарын Он тооллын бичигт монголын дархад үндэстний хувцас хэрэглэл, соёл, заншлыг дүрслэн бичсэн өгүүлэл нийтлүүлсэн нь мөн л энэ ястны тухай хамгийн дэлгэрэнгүй баримтад тооцогддог байна.

Тэрээр Монголын ардын уламжлалт тоглоом, найр наадмыг илүүд сонирхон судалж 1863 онд Эрхүүгийн “Северная пчела” / “Хойд зүгийн зөгий” / сонинд “Монголын ардын баяр – Долоон хошуу даншиг наадам” өгүүлэл нийтлүүлж байв.

“Бид төрөлх хотын гудамжуудаа хэр мэддэг вэ, тэр л хэмжээнд Я.П.Шишмарев Монголыг мэддэг” гэж Д.И.Клеменц бичсэн байдаг. Яков Парфеньевич Монгол орныг хайрлан, Хятадын эзэнт гүрний эрхшээл дор зовж буйг нь өрөвдөн “Халх, ер нь Монгол сүүлийн хэдэн жилийн турш давтагдсан ган, зудаас үүдэн тэр аяараа ядуурлаа. Урьд нь иймэрхүү байдаг ч цас зуд өнгөрснөөр байдал засардаг байсан бол одоо Монгол дахь Манжийн засгийн газрын татвар, төлөөсөд баригдсан ард түмэн сөхөрч байна” гэж 1885 онд Дорнод Сибирийн Амбан захирагчид явуулсан тайландaa тэмдэглэжээ.

Я.П.Шишмарев өөрөө Монгол орныг судлахаас гадна Төв Азийг болон манай орныг судлахаар ирж байсан том жижиг судалгааны ангийнханд тал бүрийн дэмжлэг туслалцаа үзүүлдэг байв. Тэрээр 1870 онд Я.П.Пржевальскийтай танилцсан бөгөөд түүнтэй болон түүний шавь, мөн алдарт эрдэмтэн, судлаач П.К.Козловтой олон жилийн турш нөхөрлөж захидлаар харилцаж явжээ. Түүнчлэн Г.Н.Потанин, М.М.Позднеев, В.А.Обручев, Д.И.Клеменц болон бусад олон эрдэмтэн судлаачид түүний дэмжлэг туслалцааг хүртэн явснаа, түүний ажил хэрэгч, хувийн зан чанарыг магтан бичсэн байдаг.

Монголд ажиллаж амьдарсан он жилүүдэд Я.П.Шишмарев өндөр зиндааны дипломатч, чадварлаг зохион байгуулагч, авьяаслаг судлаач болжээ. Тэрээр зөвхөн 1911 онд албаа орхисон бөгөөд консулын албыг нэг хүн нэг оронд тасралтгүй 50 жилийн турш дагнан хашсан нь дипломат албаны түүхэнд урьд хожид гараагүй явдал байх гэж Оросын судлаачид бичжээ. Түүний Монгол-Оросын харилцаанд оруулсан хувь нэмэр, гавъяаг зүтгэлийг наймдугаар Богд Жавзандамба хутагт өндрөөр үнэлж Өргөөгийн ойролцоо, Сонгинын аманд зуслангийн газар, мөн зандан модон аягаар шагнасан бөгөөд монгол-буддийн зан үйлийн уламжлалд харь шүтлэгт хүн ийм өндөр хэмжээний шан харамж хүртэж байсан удаагүй аж. Гэхдээ Я.П.Шишмарев ахайтны хамгийн том үйлс, гол гавьяа нь түүний хичээл зүтгэл, үйл ажиллагааны үрээр монголчууд өнө эртнээс орос угсаатанд элэгсэг дотно хандсаар ирсэн явдал буйзаа.

Я.П.Шишмарев 1915 оны 1-р сарын 18-нд Санкт-Петербург хотноо нас баржээ.

НОМ ЗҮЙ

1. Е.М.Даревская “Сибирь ба Монгол” Эрхүү, 1994
2. Н.Е.Единархова “Монгол дахь Орос улсын консул” номын өмнөтгөл, Эрхүү, 2001
3. П.К.Козлов “Монгол болон мөхсөн Хар хот”, СПб, 1901.